

## ТАНИЛЦУУЛГА

**"Олон улсын автотээврийн харилцааны тухай Монгол Улс болон  
Бүгд Найрамдах Словак Улс хоорондын хэлэлцээр"-ийн тухай**

Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болон "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, аюулгүй, ая тухтай үйлчилгээ үзүүлэх зам, тээвэр логистикийн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэх, тээврийн салбарын олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлж, бус нутгийн дэд бүтэц, тээврийн интеграцид нэгдэн орох замаар дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлэхээр тус тус тусгагдсан.

Тээврийн бусад төрлүүдтэй харьцуулахад өргөн уудам нутаг дэвсгэртэй, дэд бүтэц сул хөгжсөн манай улсын хувьд автотээврийн хэрэгцээ, шаардлага өсөн нэмэгдэж, тээврийн төрлүүдээр гүйцэтгэсэн нийт зорчигч тээврийн 98 хувийг, ачаа тээврийн 65 хувийг автотээврийн хэрэгслээр тээвэрлэж байна.

Монгол Улс одоогийн байдлаар Орос, Хятад, Казахстан, Украина, Турк, Беларусь, Киргиз, Латви, Ардчилсан Солонгос, Унгар, Литва, Словени зэрэг 12 улстай "Олон улсын автотээврийн харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр" байгуулан тээвэрлэлтийг гүйцэтгэж байна.

Монгол Улсын хөгжлийн бодлогод тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх, гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх зорилгоор тус яамны зүгээс Европын холбооны гишүүн улсууд болох Бүгд Найрамдах Польш, Чех, Гүрж, Словак, Холбооны Бүгд Найрамдах Герман, Хорват, Итали, Австри зэрэг улстай Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулахаар ажиллаж байна.

Монгол Улс Европын Холбоотой 1989 онд дипломат харилцаа тогтоож, улмаар 2011 онд Европын Холбоог манай "гуравдагч хөрш" хэмээн тунхаглаж, түүний гишүүн орнуудтай харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлж байна.

Манай улсаас Европын Холбоонд экспортолж буй гол нэрийн бараанд өлөн гэдэс, ноос, ноолуур, сүлжмэл бүтээгдэхүүн, эсгий, хивс, үслэг эдлэл, арьс, ширэн бүтээгдэхүүн, алт, үнэт металл, монгол гэр багтдаг.

Харин Европын Холбооноос машин, тоног төхөөрөмж, эмийн бүтээгдэхүүн, эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, гоо сайхны бүтээгдэхүүн, архи, дарс, шоколад, цай, лаазалсан ногоо, жимс, самар зэрэг хүнсний бүтээгдэхүүн голчлон импортолж байна.

Монгол, Словакийн гадаад худалдааны эргэлт 2021 онд 5.5 сая ам.долларт, хоёр улс хоорондын экспортын хэмжээ 2022 онд 2.9 сая ам.доллар хүрсэн бөгөөд цар тахлын улмаас 2019-2021 онд экспортын хэмжээ төдийлөн их биш байна. Харин Словакаас импортолсон барааны хэмжээ 2018 онд 1.4 тэрбум ам.доллар байсан бол 2022 онд 1.7 тэрбум ам.долларт хүрч, импортын хэмжээ сүүлийн 3 жилд тогтмол өссөн үзүүлэлттэй байна.

"Олон улсын автотээврийн харилцааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Словак Улс хоорондын хэлэлцээр"-ийн төслийг 2021 оны 03 дугаар сард

Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлж, уг хэлэлцээрийг байгуулах хүртэлх хугацаанд хоёр улсын хооронд автотээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрлийн бичгийг солилцож, тээвэрлэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу эхлүүлсэн.

Үүний үр дүнд 2021 оноос хойш хоёр улсын хооронд болон дамжин өнгөрөх тээврийн зөвшөөрлийн бичгийг жил бүр харилцан ижил тоотой солилцож, тээвэрлэлтийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна.

#### Хэлэлцээрийн агуулга, зарчмын хувьд:

"Олон улсын автотээврийн харилцааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Словак Улс хоорондын хэлэлцээр"-ийн тесел нь 25 зүйлээс бүрдэж байгаа бөгөөд 2017 оноос хойш хамтран ажиллаж, хэлэлцээрийн төслийг хоёр тал эзслэн тохироод байна.

Энэ хэлэлцээрийн тесел нь НҮБ-ын хоёр талт хэлэлцээрийн загварт нийцэж байгаа бөгөөд хамрах хүрээ, нэр томъёоны тайлбар, хамтарсан хороо, эрх бүхий байгууллагыг тогтоох, тээврийн үйлчилгээний төрөл, тээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрөл, зөвшөөрлийн журам, зөвшөөрлийн шаардлагаас чөлөөлөх, тээвэрлэлтийг гүйцэтгэх нөхцөл, ерөнхий шаардлагууд, тээврийн хэрэгслийн жин, овор хэмжээ, тээвэрлэгчийн үүрэг хариуцлага, татвар, даатгалын асуудал, олон улсын үүрэг хариуцлага зэрэг тээвэрлэлтийн үйл ажиллагааны зохицуулалт, баримтлах шаардлага, нөхцөлийг тусгасан болно.

Хэлэлцээрийн үндсэн агуулга, зарчим нь хөрш зэргэлдээ болон Европын орнуудын худалдаа, тээвэр, здийн засгийн харилцааг хөгжүүлэх, худалдаа, тээврийг хөнгөвчлөх, тээврийн төрлүүдийн харилцан уялдааг хангах, автотээврийн салбарын хамтын ажиллагааг дэмжих, салбарын үйл ажиллагаанд хамааралтай олон улсын байгууллагын стандарт, зөвлөмжийг хоёр тал нэгдсэн зохицуулалттай хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх явдал юм.

#### Хэлэлцээрийг байгуулснаар дараах ач холбогдолтой:

- Монголын тээвэрчид гуравдагч орнууд руу тээвэрлэлт гүйцэтгэх, олон улсын зах зээлд өрсөлдөх, дамжин өнгөрөх тээвэрлэлтийн шинэ гарц нээгдэх эрх зүйн зохицуулалт бий болно.
- Хоёр улсын хооронд ТИР конвенцын хүрээнд ачаа тээвэрлэлтийг зохион байгуулах боломж бүрдэнэ.
- Хоёр улсын хооронд гадаад худалдаа өргөжине.
- Ази-Европыг хамарсан худалдаа, тээвэр, гааль, татвар, даатгалын асуудлууд хөнгөвчлөгднө.
- Уг хэлэлцээрт шинээр худалдан авсан тээврийн хэрэгслийн анхны ачаагүй аялал нь зөвшөөрлийн шаардлагаас чөлөөлөгдхөөр заасан бөгөөд энэ нь Европын орнуудаас тээврийн хэрэгслийг худалдан авахад тээвэрлэлтийн зардал, хил, гаалийн хүндрэл, саатал буурч, цаг хугацаа, здийн засгийн хувьд ихээхэн ач холбогдолтой болно.

Асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.